Golomt Capital®

Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.02.28

Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс

НҮҮРСНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 02 сарын 28

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн 7 хоногийн даваа гарагт БНХАУ-ын Zhengzhou таваарын биржийн коксжих нүүрсний ханш 910 юань дээр нээгдэж баасан гарагт 933.2 юань дээр хаагдсанаар 2.5 хувийн уналт үзүүллээ. Даваа гарагт ханш 6.65 хувь, мягмар гарагт 6.38 хувиар өссөн бол долоо хоногийн сүүлээр ханш бага зэрэг унажээ.

Ханшийн өөрчлөлтөд ОХУ болон Украйны хурцадмал нөхцөл байдал болон газрын тос болон эрчим хүчний түүхий эд бүтээгдэхүүнүүдийн ханш өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Харин долоо хоногийн сүүлд БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хорооноос нүүрсний ханшийг барихын тулд зарим арга хэмжээг хэрэгжүүлэхээ мэдэгдсэн байна.

Үндэсний хөгжил шинэчлэлийн хорооны үзэж байгаагаар нүүрсний ханш тонн нь 570 юаниас 770 юанийн хооронд хэлбэлзэж байх нь харьцангуй үндэслэлтэй ханш юм хэмээсэн байна.

Өнгөрсөн долоо хоногт ОХУ болон Украйны хурцадмал байдлын улмаас тус улсын нүүрсний ханш түүхэн дээд ханшиндаа хүрсэн бол Австралийн Newcastle боомтоос тээвэрлэгдэж буй эрчим хүчний нүүрсний ханш тонн нь 244.29 ам.долларт хүрчээ.

Дайны нөхцөл байдлын улмаас эрчим хүчний хямрал үүсэж болзошгүй байгаа тул Европын орнууд хаагдсан уурхайнуудаа дахин ашиглалтад оруулахаа мэдэгдээд байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Golomt Capital®

ТӨМРИЙН ХҮДРИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 02 сарын 28

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт БНХАУ-ын Далианы таваарын биржид арилжаалагдаж буй төмрийн хүдрийн 5 сарын гэрээний ханш 688.5 юань дээр нээгдэж, баасан гарагт 687 юань дээр хаагдсанаар 0.2 хувийн өсөлт үзүүлжээ.

SinoSteel Futures-ийн шинжээч Cheng Peng-ийн хэлснээр Украйн ОХУ-ын хурцадмал нөхцөл байдлын улмаас БНХАУ болон АНУ-ын харилцаа хурцдах эрсдэлтэй байгаа нь гангийн бүтээгдэхүүнүүдийн экспортод сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна гэлээ.

Баасан гарагт Vale компанийн удирдлагууд “ОХУ болон Украйн улс нь төмрийн хүдрийн дэлхийн зах зээлийн 30 хувийг буюу 120 сая тонныг дангаар бүрдүүлдэг тул үүссэн нөхцөл байдал нь ханшид нөлөөлөх төлөвтэй байна гэж мэдэгдээд байна.

Украйнын төмрийн хүдэр олборлогч Ferrexpo PLC дэлхийн төмрийн хүдрийн үрлийн нийлүүлэлтийг дангаар хийдэг байна. Vale-ийн төмрийн хүдрийн зах зээл хариуцсан захирал Marcello Spinelli-ийн хэлснээр, төмрийн хүдрийн ханш өндөр хэлбэлзэлтэй байх нь гарцаагүй болсон бөгөөд гол нь хэр хугацаанд үргэлжлэх вэ гэдэг нь анхаарал татаж байна хэмээжээ.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Golomt Capital®

ЗЭСИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 2-р сарын 28

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн даваа гарагт Шанхайн таваарын биржид арилжаалагдаж буй зэсийн 11 сарын гэрээний ханш 71,510 юань дээр нээгдэж, баасан гарагт 70,960 юань дээр хаагдсанаар 0.7 хувиар уналаа.

Өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт Рио Тинто компани жилийн тайлангаа танилцууллаа. Тус компани тайлант жилд түүхэн хугацаан дахь хамгийн өндөр буюу 16.8 тэрбум ам.долларын ашигтай ажиллажээ. Тиймээс компанийн түүхэн дэх хамгийн өндөр ногдол ашгийг тараасан байна.

Тус компанийн тайлангийн үзүүлэлтүүд эерэг гарахад төмрийн хүдэр болон зэсийн ханшийн өсөлт, БНХАУ-д эрэлт өссөн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байна.

Тус компанийн ашиг өмнөх жилээс 72 хувиар өсөж 21.38 тэрбум ам.долларт хүрсэн байна. Харин тус компанийн удирдлагуудын мэдэгдсэнээр 2022 онд компанийн ашигт ажиллагаа 2021 оноос давахгүй байх төлөвтэй байна. Тиймээс 2021 оноос бага ногдол ашиг тараана гэж мэдэгдсэн байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.